



803

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 19 сарын 18 өдөр

Дугаар 283

Мандалговь


Хөрөнгө акталж устгах, худалдах
зөвшөөрөл олгох тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийт хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5.2.1, 5.8.a, 5.8.g заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 37°079'950 /гучин долоон сая далан есөн мянга есөн зуун тавь/ төгрөгийн анхны өртөгтэй, 12°238'783 /арван хоёр сая хоёр зуун гучин найман мянга долоон зуун наян гурав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг хавсралт 1-ийн дагуу акталж устгах, 2-р хавсралт дахь 2'990'000 /хоёр сая есөн зуун ерэн мянга/ төгрөгийн анхны өртөгтэй элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртөгөө нөхсөн хөрөнгийг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. 1-р хавсралт дахь хөрөнгийг акталж, ашиглаж болох эд хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнд бүртгэх, худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Дашцэрэнд даалгасугай.

3. 2-р хавсралт дахь хөрөнгийн худалдах үнийн доод хязгаарыг 500'000 /таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.



0100607

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 1-р сарын
28-р тогтоолын хавсралт 1
өдрийн
Албан ёсчмын
жагсаалт

Акталж устах хөрөнгийн жагсаалт

Д/д	Нэр	Тоо ширхэг	Ашигласан жил	ҮНЭ	Хуримтлагдсан энэдэл	Улдээгдэл өртөг
1	30 ТН Пүү	1	38	27'150	27'150	-
2	Усан сан	1	38	28'500	28'500	-
3	Пүүний байр	1	39	946'400	946'400	-
4	Толб багийн конторын барилга	1	33	29'077'300	22'147'451	6'930'449
5	Тарлаг багийн конторын барилга	1	2	7'000'000	1'691'666	5'308'334
Нийт дүн				37'079'950	24'841'167	12'238'783

Аймгийн ИТХТийн 2014 оны 12 сарын
12 өдрийн 282 тогтоолын хавсралт 2

Худалдах хөрөнгийн жагсаалт

Д/А	Нэр	Тоо ширхэг	Ашигласан жил	ҮНЭ	Хурумтлагдсан эрэжээл	Үлдэгдэл өртөг	Худалдах доодчийн санал
1	Хьюндэй Портер	1	4	2'990'000	2'990'000	0	500'000
	Нийт дүн			2'990'000	2'990'000	0	500'000